

"ДАШИНЧИЛЭН-ОРХОНЫ ГҮҮР ЧИГЛЭЛИЙН ЗАМААС ӨЛЗИЙТ СУМ, ӨЛЗИЙТ СУМААС МӨРӨН-ТАРИАЛАН ЧИГЛЭЛИЙН ЗАМЫН ТӨГСГӨЛИЙГ ХОЛБОХ 120КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ" ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ (БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ) КОНЦЕССЫН ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

2022 оны 1 дүгээр сарын
25-ний өдөр

Дугаар 05/03

Улаанбаатар
хот

Энэхүү Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120км хатуу хучилттай авто зам төслийг хэрэгжүүлэх (барих- шилжүүлэх) концессын гэрээ"-нд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ /цаашид "Нэмэлт гэрээ" гэх/-г Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Хөрөнгө оруулалтын газар болон "Шинжиан шинфа" хязгаарлагдмал хариуцлагатай компани нарын хооронд 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр байгуулагдсан "Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120км хатуу хучилттай авто зам төслийг хэрэгжүүлэх (барих- шилжүүлэх) концессын гэрээ" /цаашид "Концессын гэрээ" гэх/-ний 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг, "Шинжиан шинфа" ХХК-ийн 51 хувийн хувьцаа эзэмшигч "Си Вай Си Кэй" хязгаарлагдмал хувьцаат компанийн 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/02/55, 12 дугаар сарын 15-ны өдрийн А/02/56, "Шинжиан шинфа" ХХК-ийн 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 074, 11 дүгээр сарын 23-ны өдрийн 091, 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 098, 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 003 дугаартай албан бичгүүдээр ирүүлсэн гэрээний хугацааг сунгах тухай хүсэлтүүдийн дагуу,

Нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газар /цаашид "Эрх бүхий этгээд" гэх/-ын дарга Х.Улам-Өрнөх,

Нөгөө талаас "Шинжиан шинфа" хязгаарлагдмал хариуцлагатай компани (РД: 5238242) /цаашид "Концесс эзэмшигч" гэх/, түүнийг төлөөлөн Гүйцэтгэх захирал Ж.Бизъяабал нар Концессын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

- 1.1. Концессын гэрээний 1 дүгээр зүйлийн 1.7 дахь "2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс өмнө" гэснийг "2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө" гэж,
- 1.2. Концессын гэрээний 1 дүгээр зүйлийн 1.13 дахь хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн хуваарийг дор дурьдсанаар тус тус өөрчлөн найруулав.

№	Төлбөрийн дүн /юань/	Төлбөрийн дүн /үсгээр/	Төлбөр гүйцэтгэх огноо
1	40,744,200.00	Дөчин сая долоон зуун дөчин дөрвөн мянга хоёр зуун ам.доллар	2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө
2	27,162,800.00	Хорин долоон сая нэг зуун жаран хоёр мянга найман зуун ам.доллар	2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө

1.3. Концессын гэрээний 1.16 дахь заалтыг "Энэхүү гэрээний 1.13-т заасан эргэн төлөлтийг Засгийн газраас эргэн төлөхдөө тухайн жилийн төсвийн хуваарилалтын дагуу гүйцэтгэх ба концесс эзэмшигчийн дансанд шилжүүлнэ" гэж өөрчлөв.

1.4. Концессын гэрээний 1.29 дэх заалтыг "Концесс эзэмшигч нь авто замын хяналтын зөвлөх компанийн үлдэгдэл зардлын 70 хувийг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор Эрх бүхий этгээдийн заасан дансанд тушаасан байна. Концессын гэрээний хугацаа

сунгасантай холбоотой хяналтын зөвлөхийн зардал нэмэгдсэн тохиолдолд Концесс эзэмшигч хариуцах бөгөөд Эрх бүхий этгээдийн албан бичгээр хүргүүлсэн хяналтын зөвлөхийн нэмэлт зардлыг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд концессын хөрөнгө оруулалтын эргэн төлөлтөөс суутгана.” гэж өөрчлөв.

ХОЁР. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Энэхүү нэмэлт гэрээгээр өөрчлөлт оруулсан заалтуудаас бусад Концессын гэрээний зохицуулалт нь хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

2.2. Энэхүү нэмэлт гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд концессын гэрээний салшгүй хэсэг байна.

2.3. Нэмэлт гэрээ нь адил хүчинтэй 2 хувь үйлдэгдсэн бөгөөд концессын гэрээний адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг:

Нэр: Х.Улам-Өрнөх

Албан тушаал: Төрийн худалдан авах
ажиллагааны газрын дарга 6529909

Тамга:

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот-210349,
Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө,
Засгийн газрын IX байр, Төрийн худалдан
авах ажиллагааны газар

КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг:

Нэр: Ж.Бизъяабал

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Тэмдэг:

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот
Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо,
Царгийн хотхон, ХЦХ дангийн 12-6
тоот, “Шинжиан шинфа” ХХК байр.